

ХҮНСНИЙ НОГООНЫ ҮРСЛЭГ БОЙЖУУЛАХ

Үрслэгээр ургуулах арга

Хүнсний ногооны зарим таримлуудыг үрслэгийн аргаар тарих бөгөөд тарих хугацаа, тариалах бүс нутаг, ил болон хамгаалагдсан хөрсөнд шилжүүлэн суулгах хугацаанаас хамаарч харилцан адилгүй хугацаанд байна.

Үрслэг нь хамгаалагдсан болон ил талбайд шигүү байдлаар ургуулан тогтсон газар буюу хүлэмж, ил талбайд шилжүүлэн суулгах боломжтой залуу ургамал юм. Үрслэгээр ургуулах давуу тал нь эрт ургац авах боломжийг бүрдүүлнэ.

Үрслэгийн төрөл

Ил талбайд ургуулах үрслэгийг эртийн, дундын, оройн гэж хуваана.

Эртийн үрслэгт тухайн жилийн хамгийн эрт ургац авах боломжтой ургамлууд орох бөгөөд бөөрөнхий цагаан байцаа, цэцэгт байцаа, кольраби, лооль, цэс, чинжүү, бөөрөнхий сонгино, порей сонгино, цоохор майлц зэрэг таримлуудын эрт болцтой сортууд хамрагдана. Эдгээр таримлуудын үрслэгийг халаалттай буюу өвлийн зориулалттай хүлэмж, дарлагад бойжуулна.

Дундын үрслэгийг арай оройтуулан тарих бөгөөд нийлэг хальсан хүлэмж, түнэль, хүйтэн дарлагад ургуулна. Үүнд орой болцтой байцаа, лооль, хэмх, цэс, чинжүү зэрэг таримлууд хамаарна. Таримлын онцлогоос хамаарч үрслэгийн бойжих хугацаа 20 – 50 хүртэл хоногт үргэлжилнэ.

Оройн үрслэгийг ил талбайд, хүйтэн дарлагад ургуулдаг. Энэ хэсэгт ихэвчлэн дунд болон орой болцтой байцааны сортууд, цэцэгт байцаа, брокколи, тонх орно.

Үрслэг бойжуулах арга


- Үрийг тарилтанд бэлтгэх: Үр нь 90%-иас доошгүй соёлолтой байх ба ариутгаж бэлтгэнэ.
- Тарих талбай, хоовон бэлтгэх: үрслэг тарих хөрс шинэ буюу ариутгасан байна, хавтант хоовон ашиглах тохиолдолд хөрсний холимог болон хөвдөн хөрсийг хэрэглэнэ.
- Тарих: үрслэгийг шилжүүлэн суулгах хугацааг тухайн сортын боловсрох хоногийг харгалзан хийнэ.
- Арчлах: үрслэг ургах тохиромжтой температурыг бариулах, гэрэлтүүлэг сайтай байлгах, хөрсний чийгийг алдагдуулахгүй байна. Үрслэгийн хэмжээ томрох үед бортгонд шилжүүлэн суулгана.



Зураг 1: Хоовон (эх сурвалж: Ж.Байгалмаа)

Үрслэг бойжуулах нөхцөл

- Ургамлын өсөлт хөгжилтөд тохирсон дулаантай байлгана.
- Тохирсон шим тэжээлийг өгөх. Шим тэжээл дутагдвал ургалтын үе шатууд удааширдаг.
- Усалгааг тохируулах.
- 5-6 жинхэнэ навчтай үед талбайд шилжүүлэн суулгана.



Зураг 2: Хоовонд үр суулгасан байдал (эх сурвалж: Ж.Байгалмаа)

Шилжүүлэн суулгахад бэлэн болсон үрслэгийн байдал

1. Таримлын төрлөөс хамаарч янз бүрийн өндөртэй, жишээ нь лоолийн үрслэг 30 см
2. Хар ногоон өнгийн эрүүл навчтай
3. Навч хоорондын зай богино
4. Хүчирхэг үндэсний системтэй



Зураг 3: Бусад таримлын үрслэг (эх сурвалж: УГТХ-ийн архив)



Зураг 4: Лоолийн үрслэг (эх сурвалж: УГТХ-ийн архив)



Зураг 5: Хэмхний үрслэг (эх сурвалж: УГТХ-ийн архив)

Хүснэгт 1: Үрслэг тарих, шилжүүлэн суулгах хугацаа

Таримал, тарих хугацаа	Үр соёолох хугацаа, Талбайд шилжүүлэх хугацаа	Ургуулах онцлог
Лооль Хүлэмж: II буюу III сарын дунд үе Ил талбай: III буюу IV сар	25-30°C – д 2 долоо хоногт соёолно Сортын онцлогоос хамаарч 50-60 хоногтой үрслэг шилжүүлнэ	<ul style="list-style-type: none"> - Хайрцаг, хавтант хоовонд тарих нь 7-10 хоногоор эртжүүлнэ. 2 жинхэнэ навчтай үед цөөлнө. - Үр соёолсноос 2-3 хоногийн дараа нэмэлт гэрэлтүүлгийг 24 цаг, цаашид 14-16 цаг хэрэглэнэ. - Үндэсний систем хайрцаг, хавтант хоовонгийн гадаргууд хүрмэгц цаашид хөгжил зогсонги байдалд ордог тул бортогонд шилжүүлэн суулгана.
Чинжүү	25-30°C – д 2-3 долоо хоногт соёолно	<ul style="list-style-type: none"> - Үрийг жижиг саванд тарих ба цаашид том бортгонд шилжүүлэн суулгана.

Таримал, тарих хугацаа	Үр соёолох хугацаа, Талбайд шилжүүлэх хугацаа	Ургуулах онцлог
II сар буюу III сарын дунд үе	Талбайд 60-70 хоногтой үрслэг шилжүүлнэ	- Нэмэлт гэрэлтүүлэг шаардлагатай: эхний үед 14-16 цаг, 2-4 жинхэнэ навч гарсан үед 10-12 цаг 7-8 жинхэнэ навчтай үед орой нахиаг танах нь хажуугийн салбар нахиа үүсэж арвин ургац авна.
Цэс II сар буюу III сарын дунд үе	25-30°C – д 2-3 долоо хоногт соёолно Талбайд 60-70 хоногтой үрслэг шилжүүлнэ	- Үрслэг шилжүүлэлт муу даадаг тул үрийг жижиг саванд тарих ба цаашид том бортогонд шилжүүлэн суулгана. - Гэрэлд мэдрэмтгий тул эхний үед 14-16 цаг байлган оройн 6 цагаас өглөө хүртэл харанхуйг үүсгэнэ. Үрслэгийг залуу үед нь шилжүүлэн суулгах
Байцаа Бөөрөнхий байцаа: III сарын дунд үе Цэцэгт болон бусад байцаа: III сарын сүүлээр	20-25°C – д 2 долоо хоногт соёолно Талбайд 45 хоногтой үрслэг шилжүүлнэ	- Бортогонд таривал гол үндэсний систем гэмтэхгүй. - Үр соёолж эхэлмэгц агаарын хэмийг 6-80C хүртэл буулгахад үрслэг сунахгүй. - Байцааны үрслэгийг сэрүүвтэр, гэрэлтэй нөхцөлд бойжуулна.
Сонгино II сар буюу III сарын дунд үе	20-25°C – д 7-10 хоногт соёолно Талбайд 60 хоногтой үрслэг шилжүүлнэ	- 90-120 нүхтэй хавтант хоовонд тарих. - Хайрцганд ургамал хооронд 1-1.5 см, мөр хооронд 2.5-3 см зайтай тарих. Маш удаан соёолдог тул тарихын өмнө 400C халуун бүлээн усанд дэвтээж аажмаар температурыг багасган усыг 3-4 удаа солино.
Хэмх, тарвас, амтат гуа	23-25°C – д 3-4 хоногт соёолно Талбайд 30-40 хоногтой үрслэг шилжүүлнэ	- Үр соёолж эхэлмэгц агаарын хэмийг 180C хүртэл буулгахад үрслэг сунахгүй. - Гэрэлтүүлэг сайтай байх, хөрсийг тогтмол чийгтэй байлгах.

Үрслэг шилжүүлэн суулгах үед анхаарах зүйл

- Үрслэг шилжүүлэн суулгах талбайн хөрсийг чийгтэй байлгах,
- Үрслэг шилжүүлэн суулгах үед үрслэг өөрөө чийгтэй байх,
- Жижиг буюу сул хөгжилтэй, өвчин хортонд нэрвэгдсэн үрслэгийг тарихгүй заазлах,
- Шилжүүлэн суулгах үед нар салхинд гандаахгүй байх,
- Үрслэгийн хэмжээнээс хамаарч тохиромжтой гүнд суулгах,
- Үрслэгийн үндэс авалтыг хурдасгах зорилгоор шилжүүлэн суулгаснаас хойш 5 мм хэмжээгээр услах,
- Үрслэг шилжүүлэн суулгахаас өмнө буюу шилжүүлэн суулгаснаас долоо хоногийн дараа хортны эсрэг фунгицид хэрэглэх.

ЗӨВЛӨМЖ

- Хүнсний ногоог тариалах бүсээс хамааран хүлэмж болон ил талбайд тарих хэдий ч сортын онцлогоос хамаарч тохиромжтой тарих нөхцөлийг сонгох шаардлагатай.
- Үрийг тарьснаас хойш 2 сарын хугацаанд бойжуулан талбайд шилжүүлнэ.
- Үрслэг бойжуулах хамгийн тохиромжтой дулаан 22⁰C ба услах, цөөлөх, сийрүүлэх, бордох арга ажиллагаануудаас бүрдэнэ.

Ашигласан хэвлэл:

Ган Гуан Рюүнь “Хүлэмжинд лооль болон хэмх тариалах технологи”, УБ 2010

Марков В.М., “Овощеводство”, Москва 1974

Миттлайдер Р., “Курс овощеводства” Тульская область 2012

Чулуунбаатар Ж., “Ногооны аж ахуй”, УБ 2011

Эмхэтгэн боловсруулсан:	Герман-Монголын Хамтын Ажиллагааны „Тогтвортой Хөдөө Аж Ахуй“ Төсөл
Хаяг:	Засгийн газрын IXа байр, Энхтайвны өргөн чөлөө 16а, Улаанбаатар 13381, Монгол улс
Мэйл:	project.mn@iakleipzig.de
Вэб хуудас:	www.dmkn.de
Текст	УГТХ-ийн хүнсний ногоо судлалын секторын эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Ж.Байгалмаа, мэйл хаяг: bbaigal70@gmail.com
Тайлбар	Энэхүү мэдээллийн богцонд багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.